

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	4
2. Аудитын тайлан	6
2.1. Оршил.....	6
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	6
2.3. Аудитын явцад МӨРДСӨН БОДЛОГО, ЖУРАМ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	7
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн	8
2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	8
2.8.2 Авлага.....	9
2.8.3 Урьдчилгаа	10
2.8.4 Бараа материал	10
2.8.5 Нөөцийн бараа	11
2.8.6 Бусад эргэлтийн хөрөнгө	12
2.8.7 Үндсэн хөрөнгө	12
2.8.8 Урт хугацаат хөрөнгө оруулалт	13
2.8.9 Өр төлбөр	14
2.8.10 Засгийн газрын хувь оролцоо.....	15
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	16
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	17
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	18
2.12. Шилэн дансны мэдээлэл	18
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	18
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	18
3. Менежментийн захидал.....	19
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	23
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	23
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	24
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	25
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	26
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	27
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	28
5.Хавсралт.....	29
5.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	29
5.2 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	31
5.3 Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар тогтоосон төлбөрийн актын нэгтгэл.....	33
5.4 Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар хүргүүлсэн төлбөрийн албан шаардлагын нэгтгэл.....	34

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ДЦС-2	Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК
ДЦС-3	Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК
ДЦС-4	Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК
ДДЦС	Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК
ЭДЦС	Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК
УБЦТС	Улаанбаатарын цахилгаан түгээх сүлжээ ТӨХК
БЗӨБЦТС	Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК
ДБЭХС	Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК
ЦДҮС	Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ ТӨХК
ДДС	Дарханы дулааны сүлжээ ТӨХК
БДС	Багануурын дулааны Станц ТӨХК
НДС	Налайхын Дулааны Станц ТӨХК
ББЭХС	Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК
АУЭХС	Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК
ДҮТ	Диспетчерийн үндэсний төв
ДШГ	Дулаан Шарын гол ТӨХК
ӨБЦТС	Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК
УБДС	Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК
АДС	Амгалан дулааны станц ТӨХК
ЭГУЦС	Эгийн голын УЦС ТӨХК
ЭБЦТС	Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК
УДС	Увсын ДС ТӨХК
ХДС	Ховдын ДС ТӨХК
ХөДС	Хөвсгөл ДС ТӨХК
ЭХЭЗХ	Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААҮГ
ЭХХТ	Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААҮГ
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
СЭХҮТ	Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД
Ц.ДАВААСҮРЭН ТАНАА

2020.04.24 № 1439
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС, НББОУС, СТОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

A red rectangular official stamp is placed over a handwritten signature in black ink. The stamp contains a central emblem and text in Mongolian script. The signature is written in a cursive style across the stamp.

Д.ЗАНДАНБАТ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн салбарын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг сайжруулан боловсруулах, төсвийг үр ашигтай зарцуулах, зорилтот түвшнийг батлахдаа үндэслэлтэй тогтоох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 4 дүгээр сарын 06-наас 2020 оны 4 дүгээр сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын аудитор Г.Түвшинзаяа, гэрээт аудитор Б.Мөнгөнцэцэг нар гүйцэтгэв.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн а/1103 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе

шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрчим хүчний яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн өсөлтийг хангахуйц эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлж, хүний эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах болон үйлдвэрлэл, үйлчилгээний найдвартай, тогтвортой нөхцөлийг хангахад оршино гэж тодорхойлжээ.

Эрчим хүчний яамны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгажээ.

Үүнд:

- Эрчим хүчний салбарын хууль тогтоомжийн төсөл, бодлогын хувилбар, дүрэм, журам, төлөвлөгөө боловсруулах, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн бодлогын удирдамжаар хангах;
- Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн туслалцаа үзүүлэх, аппаратын санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцах, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах;
- Эрчим хүчний салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр төсөл, дүрэм, журмын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, салбарын нэгдсэн үйлдвэрлэлийн төлөвлөлт хийх, аюулгүй байдлыг хангуулах;
- Түлш(нүүрс)-ний нөөцийг бүрдүүлэх, хийн ашиглалтыг нэвтрүүлэх талаар хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хувилбар, төсөл болон дүрэм, журмын төсөл боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, хэрэгжилтийг хангуулах;
- Салбарын бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хяналт, хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, хяналт шалгалт, аудит хийх, статистик мэдээлэл гаргах, хэрэглэгчийг судалгаа, мэдээллээр хангах.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт оруулвал зохих өөрчлөлт, шинэчлэлт хийгдээгүй байна. Тухайлбал: Сангийн сайдын 2017 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-тай нийцүүлээгүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх үр дагавартай байна.

Эрчим хүчний яамны үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

Эрчим хүчний яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь Эрчим хүчний сайдын 2019 оны 1 дүгээр тогтоолоор баталсан аудитын төлөвлөгөөнд тусгагдсан 10 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийж, санхүү, нягтлан бодох

бүртгэлийн чиглэлээр 107 зөвлөмж өгсөн байна. Тус газраас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтээ үнэлж, биелэлт 93.4 хувьтай гэж үнэлсэн байна.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 13,532.7 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрсэн нь дотоод хяналт үр нөлөөгүй бөгөөд нийтлэг гаргасан алдаа, зөрчилд анхаарал хандуулан дотоод аудитын төлөвлөгөөнд тусгаж ажиллах хэрэгтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 188,968.8 сая төгрөгийн 2 хувь буюу 3,779.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардал 1,886,612.5 сая төгрөгийн 2 хувь буюу 37,732.3 сая төгрөгөөр тогтоолоо.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 30 төрийн өмчит компаниудын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн бөгөөд нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайланд борлуулалтын орлого, борлуулсан бүтээгдэхүүний өртөг бүртгэгдэхгүй, зөвхөн нийт ашгийн дүнгээр тайлагнадаг байна. Иймд үр дүнгийн тайлангийн нийт зардлыг суурь болгон сонгоход нэгтгэгдсэн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн бүрэн хамрагдахгүй тул материаллаг байдлын суурь үзүүлэлтийг өөрчилж мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлыг суурь болгон сонгосон.

2.8 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 56,213.5 сая, эцсийн үлдэгдэл 46,879.6 сая төгрөг болж, 9,333.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
МӨНГӨН ХӨРӨНГӨ	56,213.5	46,879.6	(9,333.9)
Кассанд байгаа бэлэн мөнгө	283.0	387.4	104.4
Төгрөг	282.7	387.1	104.4
Гадаад валют	0.3	0.3	-
Банкинд байгаа бэлэн мөнгө	55,898.1	46,400.2	(9,497.9)
Төгрөг	42,579.6	42,098.5	(481.1)

/сая төгрөг/

Төрийн сангийн харилцах	9,664.4	13,336.4	3,672.0
Арилжааны банк дахь харилцах	32,915.2	28,762.1	(4,153.1)
Гадаад валют	13,318.6	4,301.8	(9,016.8)
Арилжааны банк дахь харилцах	13,318.6	4,301.8	(9,016.8)
Замд яваа мөнгөн хөрөнгө	32.4	92.1	59.6
Дүн	56,213.5	46,879.6	(9,333.9)
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	9,629.3	13,336.4	3,707.1
Төсөл/ сан	12,521.7	3,732.2	(8,789.5)
ТӨҮГ болон ОНӨҮГ	34,062.5	29,811.0	(4,251.5)
Дүн	56,213.5	46,879.6	(9,333.9)

Эх сурвалж: ЭХСайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Кассад байгаа бэлэн мөнгөний үлдэгдэл 387.4 сая төгрөг бөгөөд өмнөх оны мөн үеэс 104.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Кассын үлдэгдлийн 99.9 хувь буюу 387.2 сая төгрөг төрийн өмчит 30 байгууллагуудын мөнгөн хөрөнгө байна.

Банканд байршиж буй 46,400.2 сая төгрөгийн гадаад валютаарх үлдэгдэл 4,301.8 сая төгрөг нь 15 байгууллагын, 13,336.4 сая төгрөг нь Эрчим хүчний яамны төрийн сангийн харилцах данс, 28,762.1 сая төгрөг нь 32 байгууллагын арилжааны банкин дахь харилцах дансны үлдэгдэл байна.

Замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 92.1 сая төгрөг 4 байгуулагад хамаарах ба үлдэгдэл өсөхөд “Таван толгойн түлш” ХХК-ийн оны сүүлийн өдөр хийсэн 66.1 сая төгрөгийн нүүрсний борлуулалтын орлогын гүйлгээ нөлөөлсөн.

2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 70,130.9 сая, эцсийн үлдэгдэл 82,381.8 сая төгрөг болж, 12,262.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	5.2	3.5	(1.7)
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	19.3	19.3
Дансны авлага /ТӨҮГ/	56,882.2	69,735.2	12,853.0
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	3,687.2	3,568.4	(118.8)
Бусад авлага	9,556.1	9,055.4	(500.7)
Байгууллагаас авах авлага	9,544.5	9,017.4	(527.1)
Хувь хүмүүсээс авах авлага	11.6	38.0	26.4
Дүн	70,130.9	82,381.8	12,250.9
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	1.5	0.9	(0.6)
Төсөл/ сан	14.4	2.6	(11.8)
ТӨҮГ болон ОНӨҮГ	70,115.0	82,378.3	12,263.3
Дүн	70,130.9	82,381.8	12,250.9

Эх сурвалж: ЭХСайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл 82,381.8 сая төгрөг буюу өмнөх оноос 12,250.9 сая төгрөгөөр өссөн нь Төрийн өмчит үйлдвэрийн газрын тайлант оны авлагын өсөлтөөс шалтгаалсан байна. Тухайлбал: “Таван толгойн түлш” ХХК 9,285.5 сая, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК 6,135.1 сая төгрөгөөр тус тус нэмэгджээ.

Авлагын өсөлтөд 2018-2019 онд шөнийн цахилгаан тарифыг тэглэсэн татаас санхүүжилт төсвөөс дутуу олгогдсоноос, төсөвт байгууллагуудын түлш халаалтын зардлын төсөв хуучин тарифаар батлагдсан тул төсөв хүрэлцээгүйгээс төлбөрөө барагдуулдаггүй зэрэг нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Шүүх хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэхээр хандсан ч нотлох баримтгүй, шүүхийн шатанд маргаантай, төлөгдөх эсэх нь тодорхойгүй 1,294.9 сая төгрөгийн авлага байна. /УБЦТС ТӨХК 433.3 сая төгрөг, Дулааны IV цахилгаан станц ТӨХК 219.1 сая, Дарханы дулааны сүлжээ ТӨХК 41.5 сая, Эрчим хүчний хөгжлийн төв 601.0 сая/
- Нийт 288.6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, /Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв 13.6 сая, Ховд дулааны станц ТӨХК 27.9 сая, Даланзадгадын ДЦС ТӨХК 25 сая, Дулааны шарын гол ТӨХК 29.6, Дарханы дулааны сүлжээ ТӨХК 19.6 сая, ЭХХТ ТӨҮГ 96.1 сая, ЭБЦТС ТӨХК 76.8 сая/

2.8.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 97,613.0 сая, эцсийн үлдэгдэл 107,315.9 сая төгрөг болж, 9,702.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	97,581.2	104,273.6	6,692.3
Урьдчилгаа тооцоо	31.7	3,042.3	3,010.6
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	31.7	52.3	20.6
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	-	2,990.0	2,990.0
Дүн	97,613.0	107,315.9	9,702.9
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	-	1,397.8	1,397.8
Төсөл/ сан	14,628.3	14,628.3	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	82,984.7	91,289.8	8,305.1
Дүн	97,613.0	107,315.9	9,702.9

Эх сурвалж: ЭХСайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 9,702.9 сая төгрөгөөр өссөн бөгөөд 1,397.8 сая төгрөг нь төсөвт байгууллага, 8,305.1 сая төгрөг нь Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд байна.

Урьдчилж гарсан зардал дансны их хэмжээний үлдэгдэлтэй байгууллагуудыг дурдвал:

- Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 67,088.0 сая төгрөгийн үлдэгдлээс 66,758.9 сая төгрөг нь Турбин генератор-5 төслийн гадаадын зөвлөх компанийн зардал, төслийн зургийн төлбөрийн тооцоо, 71.2 сая төгрөг нь 2019 онд ажил үйлчилгээ нь хийгдэж дуусаагүй дараа онд үргэлжилж байгаа хүчил төрөгчийн станцын шинэчлэлийн материал, хяналтын гэрээт ажлын урьдчилгаа, 257.9 сая төгрөг нь Шарын голын болон Багануурын уурхайн нүүрсний тээврийн зардлын урьдчилгаа төлбөр;
- Дулааны цахилгааны станц-3 хөрөнгө оруулалттай холбоотойгоор “Комфорт импекс” ХХК-д шилжүүлсэн 4,000.0 сая төгрөг, УБТЗ ТӨХК-д 839.5 сая төгрөгийн нүүрсний тээврийн хөлсний урьдчилгаа төлбөр;
- Эгийн голын усан цахилгаан станцын ТЭЗҮ-ийг боловсруулахтай холбогдож гарсан 11,229.5 сая төгрөгийн судалгааны ажлын хуримтлуулсан зардал;
- Таван толгойн цахилгаан станц төслийн урьдчилж гарсан зардал дансанд 14,628.3 сая төгрөгийн 2017 оноос хойш гарсан зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зардлыг хуримтлуулан бүртгэсэн байна.

2.8.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 63,026.7 сая, эцсийн үлдэгдэл 112,900.7 сая төгрөг болж, 49,874.0 сая төгрөгөөр буюу 79.1 хувиар өссөн байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	3,535.0	30,932.0	27,397.0
Тусгай зориулалттай материал	3,526.3	30,903.4	27,377.1
Эм боох материал	8.7	28.6	19.9
Дуусаагүй үйлдвэрлэл	356.3	4,190.3	3,834.0
Бэлэн бүтээгдэхүүн	357.7	1,666.5	1,308.8
Хангамжийн материал	58,682.1	76,036.2	17,354.1
Бичиг хэргийн материал	630.7	513.5	(117.2)
Аж ахуйн материал	2,103.9	2,043.0	(60.9)
Сэлбэг хэрэгсэл	30,870.2	36,827.4	5,957.1
Түлш, шатах тослох материал	13,682.6	16,190.2	2,507.6
Барилгын засварын материал	6,179.2	6,895.5	716.2
Хүнсний материал	207.3	129.7	(77.6)
Бусад хангамжийн материал	5,008.2	13,437.0	8,428.8
Мал амьтад	95.6	75.7	(19.8)
Дүн	63,026.7	112,900.7	49,874.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	25.2	22.3	(3.0)
Төсөл/ сан	6.2	9.1	2.9
ТӨҮГ болон ОНӨҮГ	62,995.3	112,869.3	49,874.1
Дүн	63,026.7	112,900.7	49,874.0

Эх сурвалж: ЭХСайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 49,874.0 сая төгрөгөөр өсөхөд түүхий эд материал 27,397.0 сая, дуусаагүй үйлдвэрлэл 3,834.0 сая, бэлэн бүтээгдэхүүн 1,308.8 сая, хангамжийн материал 17,354.1 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Үүнд “Таван толгой түлш” ХХК-ийн 27,072.2 сая төгрөгийн тусгай зориулалтын материал шахмал түлшний түүхий эд материалыг их хэмжээгээр нөөцлөн худалдан авсан, 9,954.9 сая төгрөгийн хангамжийн материал нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

- “ЭБЦТС” ТӨХК ашиглалтад тавьж олгосон, зарцуулсан 358 нэр төрлийн 118.6 сая төгрөгийн бараа материалыг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй;
- “Амгалан дулааны станц” ТӨХК тухайн станцыг барьж ашиглалтад өгсөн БНХАУ-ын машин инженерийн компанийн баталгаат хугацаа 2019.07.26-нд дууссантай холбоотой гүйцэтгэгч байгууллагын үлдээсэн 248 нэр төрлийн 5998 ширхэг бараа материалыг бүртгэлд тусгаагүй;
- “Таван толгойн түлш” ХК тайлант хугацаанд “Энержи ресурс” ХХК-иас үнэ төлбөргүйгээр авсан 706,382.38 тонн угаасан нүүрсний өртгийг тээвэрлэлтийн хөлсөөр тооцож түүхий эд материалын өртөгт шингээсэн;
- Эрчим хүчний зохицуулах хороо худалдан авах ажиллагааг сонгон шалгаруулалт хийхдээ 2 төрлийн 89.9 сая төгрөгийн худалдан авалтыг цахим системд мэдээллийг байршуулаагүй;
- “УБЦТС” ТӨХК 2006 оноос хойш одоог хүртэл үйл ажиллагаандаа огт ашигладаггүй, эргэлтгүй болсон нийт 967.5 сая төгрөгийн сэлбэг хэрэгслийн бараа материал байна.

2.8.5 Нөөцийн БАРАА

Нөөцийн барааны эхний үлдэгдэл 1,732.1 сая, эцсийн үлдэгдэл 1,807.9 сая төгрөг болж, 75.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нөөцийн бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Барааны нөөц	1,732.1	1,808.0	75.9
Дүн	1,732.1	1,808.0	75.9
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,732.1	1,808.0	75.9
Дүн	1,732.1	1,808.0	75.9

Эх сурвалж: ЭХСайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нөөцийн бараа материалын үлдэгдэлд тайлант оны эцэст 1,808.0 сая төгрөгийн мазут, нүүрс гэх мэт түүхий эд материалыг гэнэтийн дулааны эрчим хүч алдагдах үед ашиглах зорилгоор нөөцөлжээ. Тухайлбал: “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК 405.6 сая, “ДЦС-4” ТӨХК 1,084.5 сая, “УБДС” ТӨХК 243.3 сая, “Хөвсгөл аймгийн дулааны сүлжээ” ТӨААТҮГ 74.5 сая төгрөгийн нөөцийн барааны үлдэгдэл байна.

2.8.6 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгийн эхний үлдэгдэл 440,225.2 сая, эцсийн үлдэгдэл 272,728.1 сая төгрөг болж, 167,497.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6 Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө	440,225.2	272,728.1	(167,497.1)
Дүн	440,225.2	272,728.1	(167,497.1)
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	440,225.2	272,186.2	(168,039.0)
ТӨҮГ болон ОНӨҮГ	-	541.9	541.9
Дүн	440,225.1	272,728.1	(167,497.1)

Эх сурвалж: ЭХСайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл 167,497.1 сая төгрөгөөр буурахад тайлант онд “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь 541.9 сая төгрөгийн дуусаагүй барилга хүлээн авч, Дарханы дулааны цахилгаан станцын турбины шинэчлэлт төсөл татан буугдсантай холбоотой 11,390.6 сая төгрөг, Эрчим хүчний яам 161,295.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг улсын комисс хүлээж авч, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн зэрэг нь нөлөөлжээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон ашиглагч байгууллагад шилжүүлээгүй 272,728.1 сая төгрөг улсын комиссын акт гараагүйгээс шалтгаалан энэ дансанд бүртгэлтэй байна. Эрчим хүчний яаманд олон жил болж байгаа ашиглагч байгууллагад шилжүүлээгүй 4,517.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил байна.

2.8.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,761,972.2 сая, эцсийн үлдэгдэл 3,115,852.0 сая төгрөг болж, 353,879.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	2,493,615.8	2,838,729.6	345,113.8
Биет бус хөрөнгө	266,978.6	267,371.0	392.4
Бусад хөрөнгө	1,377.8	9,751.4	8,373.6
Дүн	2,761,972.2	3,115,852.0	353,879.8

<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	10,040.2	4,453.5	(5,586.7)
Төсөл/ сан	473.1	195.8	(277.3)
ТӨҮГ болон ОНӨҮГ	2,751,458.9	3,111,202.7	359,743.8
Дүн	2,761,972.2	3,115,852.0	353,879.8

Эх сурвалж: ЭХСайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн данс 353,897.8 сая төгрөгөөр өсөхөд “ДЦС-4” ТӨХК 255,180.6 сая, “Таван толгой түлш” ХХК-д 53,603.0 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ. Тус 2 байгууллагын өсөлт нийт өсөлтийн 87.2 хувийг эзэлж байна.

Тайлант онд барилга байгууламж 35,612.0 сая, авто тээврийн хэрэгсэл 23,884.0 сая, машин, тоног төхөөрөмж 277,731.7 сая, тавилга эд хогшил 2,609.5 сая, бусад үндсэн хөрөнгө 120,704.9 сая, дуусаагүй барилга байгууламж 5,346.9 сая, бусад биет бус хөрөнгө 2,362.9 сая, бусад эргэлтийн бус хөрөнгө 8,628.4 сая төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 150,506.7 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 50,837.7 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 43,451.8 сая, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлж авсан 6,963.9 сая, бусад эх үүсвэрээс 237,236.4 сая, дахин үнэлгээний нэмэгдлээр 465,700.5 сая төгрөгөөр нэмэгдсэн, балансаас баланст шилжүүлсэн 42,055.3 сая, акталсан 70,225.8 сая, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 4,999.7 сая, бусад 32,304.3 сая, дахин үнэлгээний хорогдлоор 328,231.7 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд 20,868.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь барилга, байгууламжийг хүлээж авах улсын комиссын акт, ашиглагч байгууллагад шилжүүлэх шийдвэр гараагүйгээс барилгууд бүртгэлтэй хэвээр байна. Тухайлбал: “БЗӨБЦТС” ТӨХК 5,490.7 сая, “ДЦС-3” ТӨХК 133.3 сая, “УБДС” ТӨХК 382.5 сая, “ЭБЦТС” ТӨХК 6,173.4 сая, “ЭХЗГ” 2,565.5 сая, “ЭХТТ” ТӨХК 3,799.5 сая, ЭХЯ-д 2,323.8 сая төгрөгийн дуусаагүй барилга байна.

Аудитын илрүүлэлт:

- “ДЦС-4” ТӨХК нь их засварын зардлын төсвөөс 226.8 сая төгрөг, урсгал засварын зардлаас 48.3 сая төгрөг, бараа материалын худалдан авах зардлаас 2.6 сая төгрөг нийт 277.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаагдаагүй үндсэн хөрөнгө худалдан авсан байна. Мөн Турбоагрегат №4-ийн их засварын ажилд 570.0 сая төгрөгийн материал төлөвлөж, 717.7 сая төгрөгийн материал, 432.9 сая төгрөгийн ажлын хөлсний гүйцэтгэл гарч төлөвлөсөн дүнгээс 580.6 сая төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан
- “ЦДҮС” ТӨХК-ийн 2013 онд 250.0 сая төгрөгөөр худалдан авч, нэмж 435.9 сая төгрөгийн их засвар хийсэн объектыг зориулалтын дагуу ашиглаагүй, ашиглах боломжгүй байсан асуудлаар компанийн өмнөх удирдлагыг шүүхэд хандсанаар шүүх барилгыг 141.8 сая төгрөгөөр үнэлж, зөрүү 108.2 сая төгрөгийг өмнөх компанийн удирдлагаар буцаан төлүүлэх шийдвэр гарсан боловч тухайн объектын засварт зарцуулсан 435.9 сая төгрөгийг хууль, хяналтын байгууллага шийдвэрлээгүй байна. Иймд уг объектын шүүхийн үнэлгээ болон засварын хуримтлагдсан зардал нийт 553.9 сая төгрөгийн дүн дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй хэвээр байна.
- “УБДС” ТӨХК-ийн биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 2000 оны “Зохиогчийн эрх барааны тэмдэг” 34.5 сая төгрөг, 2012 оны “Бар кодын программ” 0.5 сая төгрөг, 2014 оны “Цайны газрын удирдлагын программ” 1.5 сая төгрөг нийт 36.5 сая төгрөгийн анхны өртгөө нөхсөн хэрэгцээ шаардлагагүй, ашиглалтгүй программыг данс бүртгэлээс хасах арга хэмжээг авч ажиллаагүй;
- “Амгалан дулааны станц” ТӨХК нь данс бүртгэлд тусгаагдаагүй газар чөлөөлөлтийн хамааралтай 4 ш хуучин барилга байгууламж, 2013 онд газар чөлөөлөлтийн ажил гүйцэтгэж байсан “Пегасус Сапплайн” ХХК-иас Амгалан Дулааны Станц ашиглалтын Өмнөх Захиргаанд хүлээлгэн өгсөн сендвичэн байрыг ТӨБЗГ-ын зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлсэн.

2.8.8 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны эхний үлдэгдэл 13,488.1 сая, эцсийн үлдэгдэл 7,851.9 сая төгрөг болж, 5,636.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №8. Урт хугацаат хөрөнгө оруулалт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	13,488.1	7,851.9	(5,636.2)
Урт хугацаат зээл	13,488.1	7,851.9	(5,636.2)
Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	13,488.1	7,851.9	(5,636.2)
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл	13,488.1	7,851.9	(5,636.2)
Дүн	13,488.1	7,851.9	(5,636.2)
Үүнээс, байгууллагын төрлөөр			-
ТӨҮГ болон ОНӨҮГ	13,488.1	7,851.9	(5,636.2)
Дүн	13,488.1	7,851.9	(5,636.2)

Эх сурвалж: ЭХсайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн салбарын харьяа бусад төрийн өмчит байгууллагуудад гадаадын зээлээс дамжуулан зээлдүүлсэн урт хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэл 7,851.9 сая төгрөг байна.

2.8.9 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 893,715.7 сая, эцсийн үлдэгдэл 1,197,939.6 сая төгрөг болж, 304,223.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №9 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	156,842.0	183,948.6	27,106.6
Богино хугацаат зээлийн өглөг	50,589.4	38,038.1	(12,551.3)
Төгрөг	40,840.4	19,079.2	(21,761.3)
Гадаад валют	9,749.0	18,959.0	9,210.0
Өглөг	82,250.1	118,084.5	35,834.4
Урьдчилж орсон орлого	24,002.5	27,826.0	3,823.6
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	736,873.8	1,013,991.0	277,117.2
Урт хугацаат зээл	736,873.8	1,013,991.0	277,117.2
Төгрөг	470,925.9	727,230.7	256,304.8
Гадаад валют	265,947.9	286,760.3	20,812.4
Төслийн зээл	39,517.5	47,424.1	7,906.7
Бусад гадаад эх үүсвэр	831.1	4,023.1	3,192.0
Хойшлогдсон өр төлбөр /ТӨҮГ/	128,823.7	125,956.6	(2,867.1)
Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	96,775.6	109,356.4	12,580.8
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	893,715.7	1,197,939.6	304,223.9
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	9,482.2	13,337.2	3,855.0
Төсөл, сан	39,911.2	41,279.2	1,368.0
Төрийн сан			-
ТӨҮГ болон ОНӨҮГ	844,322.3	1,143,323.2	299,000.9
ДҮН	893,715.7	1,197,939.6	304,223.9

Эх сурвалж: ЭХсайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 183,948.6 сая төгрөг болсон нь өмнөх оноос 27,106.6 сая төгрөгөөр өсч үүнд өглөг 35,834.4 сая, урьдчилж орсон орлого 3,823.6 сая төгрөгөөр нэмэгдсэн бол богино хугацаат зээлийн үлдэгдэл 12,551.3 сая төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Барьцаа дансанд хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлийн баталгаа 9,000.3 сая төгрөг, дуусаагүй ажлын 4,336.6 сая төгрөгийн санхүүжилт нийт 13,336.9 сая төгрөг байршуулсан байна. Уг дансанд 2010-2018 онд хамаарах 51 ажлын 2,390.2 сая төгрөгийн барьцаа хөрөнгө шийдвэрлэгдээгүй хэвээр байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 1,013,991.0 сая төгрөг буюу өмнөх оноос 277,117.2 сая төгрөгөөр өссөн Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын зээл байна.

Урт хугацаат өр төлбөрийн өсөлтөд “Таван толгойн түлш” ХХК-ийн 111,768.4 сая төгрөгийн “Эрдэнэс таван толгой” ХК-ийн санхүүжилтийн өглөг, “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн 143,565.9 сая төгрөгийн Сангийн яамны “Зуух 1-8 үнс үлээлгэ, 5-8-ын бул тавагны шинэчлэлтийн төсөл” болон Хөгжлийн банкны “ТА 1-4 шинэчлэх ЗГ-ДЦС-3 2018-19 төсөл” -ийн зээлүүд нөлөөлсөн байна.

Урт хугацаат өр төлбөрийн их хэмжээний үлдэгдэлтэй байгууллагуудыг дурдвал:

- “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК Тайширын усан цахилгаан станцыг барьж байгуулах хөрөнгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор 2000 онд “Кувейтийн сан” болон Эрчим хүчний удирдах газрын хооронд байгуулсан гэрээгээр 21.1 сая ам долларын зээлийг 22 жилийн, 2006 онд “Абу-Даби сан” болон “Эрчим хүчний судалгаа хөгжлийн төв”-ийн хооронд байгуулсан гэрээгээр 13.0 сая ам долларын зээлийг 20 жилийн хугацаатай авсан байна. Монгол Улсын Их хурлын 2010 оны 72 дугаар тогтоолоор эдгээр зээлийг анх авсан үеийн ханшаар төгрөгт шилжүүлснээр 43,474.1 сая төгрөг зээл;
- “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК Хөгжлийн банкнаас Турбоагрегат 1-4 шинэчлэлд зориулж авсан 177,095.5 сая төгрөгийн үндсэн зээл болон 1,154.4 сая төгрөгийн хүүгийн өглөг, Сангийн яамнаас эрчим хүчний үр ашиг дээшлүүлэх төсөл, зуухны шинэчлэлтийн төслийн 105,464.2 сая төгрөгийн үндсэн зээл болон 1,795.3 сая төгрөгийн хүүгийн өглөг;
- “Таван толгой түлш” ХХК 111,768.4 сая төгрөгийн “Эрдэнэс таван толгой” ХК-ийн санхүүжилтийн өглөг эзэлж байна.
- “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК ХБНГУ Сэргээн Босголтын Банкны 9 төслийн 61,077.6 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн өглөг, Азийн хөгжлийн банкны төслийн 30.0 сая төгрөгийн зээл
- “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК Азийн хөгжлийн банкны 55.0 сая төгрөг, Дэлхийн банкны 33,170.5 сая төгрөгийн зээл байна.

Аудитын илрүүлэлт:

- Санхүүгийн тайланд өглөг илүү тайлагнасан “Таван толгойн түлш” ХХК 479.6 сая, “Диспетчерийн үндэсний төв” ХХК 72.6 сая
- 2004-2009 онд үүссэн боловч одоог хүртэл төлж барагдуулаагүй, төлөх эсэх нь тодорхойгүй, тооцоо нийлээгүй өглөгүүд байна. /Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК 39.6 сая/
- “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК нь 2019 онд нэр бүхий 4 ажилтанд орон сууцны зээлд дэмжлэг үзүүлэх нэг удаагийн буцалтгүй тусламж олгохоор тооцсон 80.0 сая төгрөг, Б/3147 тоот тушаалаар нэр бүхий ажилтанд нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгохоор шийдвэрлэсэн 35.4 сая төгрөгийг тус тус өглөг дансанд бүртгэж тайлагнасан
- “Диспетчерийн үндэсний төв” ХХК 2019 оны үр дүнгийн 312.4 сая төгрөгийн урамшууллыг олгох ТУЗ шийдвэр гараагүй байхад өглөгөөр тусгасан

2.8.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 2,610,686.0 сая, эцсийн үлдэгдэл 2,549,778.5 сая төгрөг болж, 60,907.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №10 Нийт цэвэр хөрөнгө өмчийн дүн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт/+, бууралт -/
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,610,686.0	2,549,778.5	(60,907.5)
Засгийн газрын оруулсан капитал	15,864.7	3,271.4	(12,593.2)
Өмч /төрийн/ ТӨҮГ/	1,283,357.8	1,287,182.5	3,824.7
Нэмж төлөгдсөн капитал	6.9	0	(6.9)
Эздийн өмчийн бусад хэсэг	341,558.5	295,052.9	(46,505.7)
Хуримтлагдсан үр дүн	224,935.1	63,835.5	(161,099.6)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	744,962.9	900,436.2	155,473.3
Дүн	2,610,686.0	2,549,778.5	(60,907.5)
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	450,439.2	278,060.0	(172,379.2)
Төсөл, сан	-12,267.5	-22,711.1	(10,443.6)
ТӨҮГ болон ОНӨҮГ	2,172,514.3	2,294,429.6	121,915.3
Дүн	2,610,686.0	2,549,778.5	(60,907.5)

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Цэвэр хөрөнгө өмчийн дүн 60,907.5 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны эздийн өмчийн бусад хэсэг данс 46,505.7 сая, хуримтлагдсан үр дүн 161,099.6 сая төгрөгөөр буурснаас, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 155,473.3 сая төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Засгийн газрын оруулсан капитал данс 12,593.2 сая төгрөгөөр буурахад 7,226.5 сая төгрөгийн Дарханы дулааны цахилгаан станц турбины шинэчлэлт төсөл татан буугдсан, мөн 5,366.7 сая төгрөгийн Эрчим хүчний яамны дуусаагүй барилга, байгууламжийг ашиглагч байгууллагад шилжүүлсэнтэй холбоотой гарсан өөрчлөлтүүд нөлөөлжээ.

Бодлогын өөрчлөлт алдааны залруулгад өмнөх үеийн үр дүнг 144,302.9 сая төгрөгөөр бууруулсан залруулга байна. Үүнд төсөвт байгууллага 206,342.3 сая төгрөгөөр, төсөл хэрэгжүүлэгч нэгжийн 6,058.0 сая төгрөгөөр бууруулах, төрийн өмчит байгууллагууд 68,097.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх залруулгууд байна.

Тайлант онд 9 ТӨХК-ийн 365.1 сая төгрөгийн ногдол ашиг зарлан, бүртгэжээ. Үүнд: “БЗӨБЦТС” ТӨХК 0.7 сая, “ДБЭХС” ТӨХК 134.3 сая, “ӨБЦТС” ТӨХК 12.5 сая, “Сэргээгдэх эрчим хүчний төв” ТӨХК 69.6 сая, “УБЦТС” ТӨХК 23.4 сая, “ЭБЦТС” ТӨХК 31.2 сая, “Эрдэнэтийн ДЦС” ТӨХК 51.6 сая, “Эрчим корпораци” ТӨААТҮГ 40.3 сая, “ЭХХТ” ТӨААТҮГ 1.5 сая төгрөгийн ногдол ашиг байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан 116,037.7 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжихээр батлагдснаас, 18,887.3 сая төгрөгийг урсгал зардалд, 97,150.4 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын зардалд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Нийт урсгал зардалд батлагдсан 18,887.3 сая төгрөгөөс 17,150.0 сая төгрөгийг эрчим хүчний үйлдвэрүүдийн цахилгаан, дулааны алдагдлын татаас, санхүүжилтийн зардалд бүрэн зарцуулсан байна. Үүнд:

Татаас, санхүүжилтийн зардлаас “Алтай Улиастай эрчим хүчний систем” ХХК 3,150.0 сая, “Дулааны Шарын гол” ТӨХК 500.0 сая, “Налайхын дулааны станц” ТӨХК 1,400.0 сая, “Даланзадгадын ДЦС” ТӨХК 1,600.0, “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК 8,600.0 сая, “Багануурын ДЦС” ТӨХК 1,100.0 сая, “Хэнтий Ус” ХХК 300.0 сая, “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ 500.0 сая төгрөгийг шилжүүлжээ.

Батлагдсан үлдэгдэл 1,737.3 сая төгрөгийн урсгал зардлын 1,706.6 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 30.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.

Хөрөнгө оруулалтын 28 төсөл, арга хэмжээнд 97,150.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 88.8 хувийг буюу 86,227.9 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Он дамжин хийгдэх дуусаагүй ажлын 3,497.1 сая төгрөгийн санхүүжилтийг барьцаа дансанд байршуулжээ.

Нэмэлт төсөв: Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 12,750.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлого орсноос “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-д 12,722.0 сая, “Улаанбаатар төмөр замын эрчим хүч, ус хангамжийн нэгдүгээр анги” ХНН-д 28.0 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

2.10 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 30 төрийн өмчит аж ахуйн нэгж, 1 төслийн нэгжийн, нийт 33 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 32 байгууллага аудитад, 1 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,073,095.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,059,562.5 сая төгрөгийн алдааг залруулж, 445.3 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож, 4,204.1 сая төгрөгийн зөрчилд 23 албан шаардлага, 8,883.3 сая төгрөгийн зөрчилд 115 зөвлөмж өглөө.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн ерөнхийлөн захирагч болон харьяа байгууллага хооронд үүссэн 1,016,152.2 сая төгрөгийн орлого болон зардлын давхардал байсныг илрүүлж, аудитын явцад залруулга хийлгэсэн.

Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн 2 байгууллагын, 1 нь түүвэрт, аудитад хамрагдсан Эрчим хүчний яам хязгаарлалттай дүгнэлт авсан байна.

Аудитаар нийт 4,821.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,377.1 сая төгрөгийн алдааг залруулж, 2,444.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд 9 зөвлөмж өглөө.

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төрийн болон орон нутгийн өмчит 30 аж ахуйн нэгж байгууллагаас “Зөрчилгүй” 28, “Хязгаарлалттай” 2 /Эгийн голын усан цахилгаан станц ТӨХК, Диспетчерийн үндэсний төв ХХК/ дүгнэлт гарсан.

Аудитаар нийт 47,093.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 36,005.7 сая төгрөгийн алдааг залруулж, 445.3 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож, 4,204.1 сая төгрөгийн зөрчилд 23 албан шаардлага, 6,437.9 сая төгрөгийн алдаа, зөрчилд 105 зөвлөмж өглөө.

Төсөл, хөтөлбөрийн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Аудитад хамрагдсан 1 төсөл хөтөлбөрийн нэгж нь “Зөрчилгүй” дүгнэлт гарсан.

Аудитаар нийт 229.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсний 228.1 сая төгрөгийн алдааг залруулж, 0.9 сая төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өглөө.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

1. Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд 2019 оны байдлаар нийт 1,013,991.0 сая төгрөгийн урт хугацаат зээл, хуримтлагдсан зээлийн хүүгийн өглөгийн өр төлбөрийг барагдуулах эх үүсвэр хэрхэн шийдэгдэх;

2. Эгийн голын усан цахилгаан станцын төсөл БНХАУ-ын Засгийн газрын 1.0 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлээр баригдаж эхэлсэн бөгөөд Дэлхийн өвд бүртгэгдсэн Байгаль нуурт нөлөөлөх тухай асуудлыг Оросын талаас Хятадын талд албан ёсоор хандсанаар төслийн ажил зогсонги байдалд хүрсэн байна. Эгийн голын усан цахилгаан станцын төслийг санхүүжүүлэх зорилгоор одоогийн байдлаар Монгол улсын Хөгжлийн банкнаас 35,212.1 сая төгрөгийн зээл авч зарцуулсан нь анхаарал татахуйц;

3. Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагууд хооронд үүссэн 1,122,074.9 сая төгрөгийн борлуулалтын орлого, борлуулсан бүтээгдэхүүний өртгийн давхардсан ажил гүйлгээний залруулгыг хийхэд Сангийн яамны Э-тайлангийн цахим системд борлуулсан бүтээгдэхүүний өртгийг орлогын дансны үзүүлтэд бүртгэлттэй байгаагаас шалтгаалан устгах бичилтийг хийх боломжгүй байгаа асуудлыг Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авч үзэхээр шийдвэрлэлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Эрчим хүчний яам нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 121 мэдээллийг хугацаанд нь, 16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээлэл байршуулах хугацаа болоогүй байна.

2.13. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид 47.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосноос 96.6 хувийг барагдуулсан, 12,475.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснээс хэрэгжилт 78.9 хувьтай байна. Нийт 85 зөвлөмж өгснөөс 75 зөвлөмжийг хэрэгжүүлж, 10 зөвлөмж хэрэгжих шатандаа зөвлөмжийн хэрэгжилт 88.2 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй дүгнэлт

Залруулагдаагүй 13,532.7 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 37,732.3 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлтийг өгч байна.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд Менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Эрчим хүчний яамны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Дээд түвшний удирдлагатай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг өндрөөр тогтоосон байгаа нь Эрчим хүчний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6-д “Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон болон тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлсөөр санхүүжнэ”, 9 дүгээр зүйлийн 9.1.18-д “эрчим хүчний зохицуулалттай үйлчилгээний хөлс тооцох аргачлал, уг үйлчилгээний хөлсний хэмжээг батлах”, Эрчим хүчний зохицуулах хорооны 494 дүгээр тогтоолын 3-д Эрчим хүчний зохицуулалтын үйлчилгээний нийт хөлсний хэмжээ нь Хорооны тухайн жилийн батлагдсан үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлын төсвийг хангахуйц байна” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна

3.1.2 Эрсдэл:

Зохицуулалтын үйлчилгээний хөлсийг өндөр тогтоосон байх, орлогыг буруу төлөвлөх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Зохицуулалтын үйлчилгээний хөлсийг ЭХЗХорооны тухайн жилийн батлагдсан үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлын төсвийг хангахуйц түвшинд тогтоох

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг дагуу ажиллах болно

3.2 Дээд түвшний удирдлагатай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Уул уурхайн компаниудад нийлүүлж байгаа цахилгааны кВт цагийн тарифийг 2015 оноос хойш индексжүүлээгүй мөн Эрчим хүчний зохицуулах хорооноос тариф дээр хөрөнгө оруулалтын шинжтэй орлогыг нэмж баталж байгаагаас барилга угсралтын ажлын зардлыг НББОУС 16-д заасны дагуу хөрөнгөөр бүртгэж авснаар тайлант онд цэвэр ашигтай тайлагнагдаж ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэвэл ногдол ашгийг төлөх мөнгөн хөрөнгийн хомсдол үүсэх эрсдэлтэй байгаа нь Эрчим хүчний тухай хуулийн 9.1.4.-т “тариф

тогтоох аргачлал боловсруулах, тарифын бүтэц тодорхойлох, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тарифыг хянаж батлах, хэрэглэгчдэд худалдах үнийг тогтоох, индексжүүлэлтийг хэрэгжүүлэх;" заалттай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Орлого буруу илэрхийлэгдэх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчит байгууллагуудын зорилтот түвшнийг батлахдаа хөрөнгө оруулалтын шинжтэй орлогыг тарифт орлогоос тусад нь баталж байх, уул уурхайн компаниудад нийлүүлж байгаа цахилгааны тарифыг шинэчлэн тогтоох

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг дагуу ажиллах болно

3.3 Дээд түвшний удирдлагатай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Эрчим хүчний тариф шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор төсөвт байгууллагуудын цахилгаан дулааны зардлын төсвийг уялдуулан батлагдахгүй байгаагаас авлага, өглөгийн хэмжээ өссөн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Авлага нэмэгдэх, найдваргүй авлага үүсэх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн төсөл хэлэлцэх үед салбарын зүгээс эрчим хүчний тариф нэмэгдсэнтэй уялдуулан төсөвт байгууллагуудын цахилгаан дулааны зардлын төсвийг нэмж батлуулахгүйгээс өр, авлагын дүн өсөх хандлагатай байгаа саналыг оруулж, батлуулах

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг дагуу ажиллах болно.

3.4 Дээд түвшний удирдлагатай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ЦДҮС ТӨХК-ийн хөрөнгө оруулалтын ажлын хөрөнгийн эх үүсвэрийг 2018 онд арилжааны банкны зээлээр санхүүжүүлэх шийдвэр гаргаж, 1,455.0 сая төгрөгийн зээлийн хүүгийн зардал төлсөн байна. Энэхүү зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөр нь Эрчим хүчний сайдын 2019 оны төсөвт батлагдсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.4.2 Эрсдэл:

Төсвийг үр ашиггүй зарцуулах

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлыг тухайн оны төсөвт батлуулж байх, үр ашиггүй зардал гаргахгүй байх

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийн дагуу ажиллана.

3.5 Дээд түвшний удирдлагатай холбоотой асуудал

3.5.1 Илрүүлэлт:

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 52,143.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 38,610.9 сая төгрөгийн алдааг залруулж, залруулагдаагүй 13,532.7 сая төгрөгийн алдаа зөрчил байна. Энэ нь харьяа байгууллагуудын санхүүгийн ажилтнуудын ур чадвар, чадавхыг дээшлүүлэх ажил хангалтгүй, дотоод хяналт үр нөлөөгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1."Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна" гэж заасантай нийцэхгүй байна.

3.5.2 Эрсдэл:

Төсвийн сахилга бат алдагдах

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Харьяа байгууллагуудын санхүүгийн ажилтнуудыг ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулах, байгууллагын удирдлагуудад тавих хяналтыг сайжруулах

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийн дагуу ажиллах болно

3.6 Хөрөнгө оруулалттай холбоотой асуудал

3.6.1 Илрүүлэлт:

Тайлант онд гүйцэтгэгч 2 компаниас нийт 21.4 сая төгрөгийн барьцааг суутган тооцоогүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43.6 дахь заалт Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг захиалагч тендерийн баримт бичигт тусгаж болно., НББ-ийн тухай хуулийн 14.4.2 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

3.6.2 Эрсдэл:

Ажил гүйцэтгэх гэрээний дагуу барьцаа хөрөнгийг суутган тооцоогүй байх

3.6.3 Өгсөн зөвлөмж:

Цаашид гэрээний дагуу барьцаа хөрөнгийг суутган барьцаа дансанд байршуулж байх

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийн дагуу ажиллах болно

3.7 Хөрөнгө оруулалттай холбоотой асуудал

3.7.1 Илрүүлэлт:

Барьцаа хөрөнгийн дансанд 2010-2018 онд байршуулсан 2,390.2 сая төгрөгийн барьцааг гүйцэтгэгч байгууллагад буцаан өгөх асуудлыг шийдвэрлээгүй байгаа нь Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсон тохиолдолд гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, захиалагч болон ашиглагч тухайн барилга байгууламжид хамтарсан үзлэг хийж, зөрчлийг арилгах талаар тэмдэглэл үйлдэнэ." 14.5.Энэ хуулийн 14.4-т заасны дагуу зөрчлийг арилгаснаар энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсонд тооцно. гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.7.2 Эрсдэл:

Дуусгавар болсон барьцаа хөрөнгийг чөлөөлөөгүй байх

3.7.3 Өгсөн зөвлөмж:

Олон жил хуримтлагдсан барьцаа хөрөнгийг гүйцэтгэгч байгууллагад буцаах асуудлыг эцэслэн шийдвэрлэх, буцаахгүй барьцаа хөрөнгийн судалгааг гаргаж улсын төсвийн орлого болгох асуудлыг шийдвэрлэх

3.7.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийн дагуу ажиллах болно

3.8 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.8.1 Илрүүлэлт:

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2017 оноос хойш шинэчлэлт хийгдээгүй, харьяа байгууллагын хооронд хийсэн давхардсан ажил гүйлгээнд устгах бичилт дутуу хийгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг холбогдох стандарт, хууль, журам, зааврын шинэчлэлтийг тусгаагүйгээс шалтгаалсан байна.

3.8.2 Эрсдэл:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан буруу илэрхийлэгдэх

3.8.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох стандарт, хууль, журмыг шинэчлэн тусгах

3.8.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийн дагуу ажиллах болно

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	728,941,413.8	624,014,122.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	56,213,532.0	46,879,637.3
33	АВЛАГА	70,130,873.3	82,381,823.1
34	УРЬДЧИЛГАА	97,612,951.5	107,315,862.7
35	БАРАА МАТЕРИАЛ	63,026,744.0	112,900,729.7
36	НӨӨЦИЙН БАРАА	1,732,123.9	1,807,961.8
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	440,225,189.1	272,728,107.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,775,460,318.9	3,123,703,955.2
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	13,488,103.4	7,851,950.9
37300	Урт хугацаат зээл	13,488,103.4	7,851,950.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,761,972,215.5	3,115,852,004.2
39200	Биет хөрөнгө	2,493,615,831.8	2,838,729,610.1
39300	Биет бус хөрөнгө	266,978,595.2	267,370,964.6
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	1,377,788.5	9,751,429.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,504,401,732.7	3,747,718,077.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	893,715,746.8	1,197,939,567.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	156,841,970.6	183,948,591.1
41200	Богино хугацаат зээлийн өглөг	50,589,433.7	38,038,115.2
41300	Өглөг	82,250,071.1	118,084,457.8
41400	Урьдчилж орсон орлого	24,002,465.7	27,826,018.0
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	736,873,776.2	1,013,990,976.2
42200	Урт хугацаат зээл	736,873,776.2	1,013,990,976.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,610,685,986.0	2,549,778,510.4
51	Засгийн газрын хувь оролцоо	2,610,685,986.0	2,549,778,510.4
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	15,864,664.9	3,271,431.5
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,283,357,813.1	1,287,182,485.3
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	6,940.0	-
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	341,558,515.5	295,052,854.1
51200	Хуримтлагдсан үр дүн	224,935,066.9	63,835,488.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	744,962,985.6	900,436,250.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,504,401,732.7	3,747,718,077.6

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	598,368,003.9	455,477,808.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	541,755,073.8	350,618,844.6
120	Нийтлэг татварын бус орлого	532,400,640.9	350,618,844.6
122	Тусламжийн орлого	9,354,433.0	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	56,612,930.1	104,858,964.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	582,175,778.8	403,431,136.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	341,372,087.3	403,431,136.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	322,182,293.7	383,715,473.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,422,600.5	1,709,464.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	290,943.3	216,893.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	273,432.7	133,870.8
2104	Хангамж, бараа материалын зардал	121,653.1	83,902.5
2105	Нормативт зардал	2,675.4	2,712.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,749.1	26,747.0
2107	Томилолт, зочны зардал	102,688.1	73,313.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	163,310,164.2	208,580,296.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	155,633,387.2	172,888,274.1
211	ХҮҮ	1,923,134.8	2,493,909.5
212	ТАТААС	17,149,933.3	17,150,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	116,725.5	71,753.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	240,803,691.5	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	16,192,225.1	52,046,672.2
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	1,198,660.6	1,184,883.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	14,572,777.4	63,923,337.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,818,108.2	(10,691,781.7)

4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,522,813,202.3	1,619,166,560.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,466,200,272.2	1,514,307,596.6
120	Нийтлэг татварын бус орлого	2,457,781,904.0	1,514,307,596.6
2	Тусламжийн орлого	8,418,368.2	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	56,612,930.1	104,858,964.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,273,551,625.4	1,483,283,890.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,273,551,625.4	1,483,283,890.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,270,773,839.1	1,473,982,169.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	197,800,819.8	231,411,050.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,946,633.1	69,489,150.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,288,305.6	21,045,038.3
2104	Хангамж, бараа материалын зардал	1,215,975,352.2	740,262,733.7
2105	Нормативт зардал	3,055.9	2,712.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,840.2	24,788.2
2107	Томилолт, зочны зардал	102,031.6	70,027.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	779,769,035.4	411,297,676.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	863,765.3	378,992.5
211	ХҮҮ	1,861,666.4	2,468,101.9
212	ТАТААС	800,000.0	800,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	116,119.9	6,033,618.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	249,261,576.8	135,882,670.7
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	4,514,526.9	2,136,085.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	290,338,371.6	353,585,071.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	290,338,371.6	353,585,071.2
2200	Дотоод эх үүсвэрээр	290,338,371.6	353,585,071.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(285,823,844.7)	(351,448,985.8)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	26,971,969.1	206,232,420.4
14	Бусад эх үүсвэр	78,702,097.5	255,975,894.5
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	35,558,767.3	-
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	16,171,361.1	49,743,474.1
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(9,590,298.8)	(9,333,894.7)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	65,803,830.9	56,213,532.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	56,213,532.0	46,879,637.3

4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,525,943,612.5	2,525,943,612.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(441,066,892.4)	(441,066,892.4)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,084,876,720.1	2,084,876,720.1
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	309,856,835.5	309,856,835.5
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(33,910,062.0)	(33,910,062.0)
6	Өмчид гарсан өөрчилөлт	248,382,873.0	248,382,873.0
7	Зарласан ногдол ашиг	(1,332,221.9)	(1,332,221.9)
8	Тайлант үеийн үр дүн	2,818,108.2	2,818,108.2
9	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,610,685,986.0	2,610,685,986.0
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(144,302,871.5)	(144,302,871.5)
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,466,389,381.4	2,466,389,381.4
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	155,312,021.3	155,312,021.3
13	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(86,128,961.8)	(86,128,961.8)
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	12,935,243.3	12,935,243.3
15	Өмчид гарсан өөрчилөлт	12,327,714.8	12,327,714.8
16	Зарласан ногдол ашиг	(365,107.0)	(365,107.0)
17	Тайлант үеийн үр дүн	(10,691,781.7)	(10,691,781.7)
18	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,549,778,510.4	2,549,778,510.4

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	116,037,664.4	105,084,498.2	10,953,166.2	90.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	18,887,340.5	18,856,600.4	30,740.1	99.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,687,639.0	1,665,785.8	21,853.2	98.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,295,687.5	1,295,332.7	354.8	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	161,960.7	146,566.1	15,394.6	90.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,706.6	78,741.6	4,965.0	94.1
2104	Хангамж, бараа материалын зардал	57,921.6	57,882.4	39.2	99.9
2105	Нормативт зардал	2,776.9	2,712.0	64.9	97.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,163.4	25,270.0	106.6	100.4
2107	Томилолт, зочны зардал	35,579.3	35,575.6	3.7	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,843.0	23,705.4	1,137.6	95.4
212	ТАТААС	17,150,000.0	17,150,000.0	-	100.0
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	17,150,000.0	17,150,000.0	-	100.0
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	17,150,000.0	17,150,000.0	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,701.5	40,814.5	8,887.0	82.1
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,400.0	2,816.3	1,583.7	64.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,301.5	37,998.2	7,303.3	83.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	97,150,323.9	86,227,897.8	10,922,426.1	88.8
220001	Барилга байгууламж	90,050,323.9	79,677,800.2	10,372,523.7	88.5
221001	Их засвар	7,100,000.0	6,550,097.6	549,902.4	92.3
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	116,037,664.4	105,084,299.5	10,953,364.9	90.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	116,037,664.4	105,084,299.5	10,953,364.9	90.6
310001	Улсын төсвөөс санхүүжих	116,037,664.4	105,084,299.5	10,953,364.9	90.6
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	198.7	198.7	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,750,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,750,000.00
212	ТАТААС	12,750,000.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	12,750,000.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	12,750,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,750,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,750,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,750,000.00

5.Хавсралт

5.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2020/04/25			САГ-2020/27/СТА-ТЕ3
Шалгагдсан байгууллагын нэр:	Эрчим хүчний яам		сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
A	3	4	5	9	10
Төсвийн ерөнхийлөн захирагч					
1	Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг өндрөөр тогтоосон байна.	-	Зөвлөмж өгөх	Эрчим хүчний сайд, Ерөнхий нягтлан бодогч	Ц.Даваасүрэн П.Энхцэлмэг
2	Уул уурхайн компаниудад нийлүүлж байгаа цахилгааны кВт цагийн тарифийг 2015 оноос хойш индексжүүлээгүй мөн Эрчим хүчний зохицуулах хорооноос тариф дээр хөрөнгө оруулалтын шинжтэй орлогыг нэмж баталж байгаагаас барилга угсралтын ажлын зардлыг НББОУС 16-д заасны дагуу хөрөнгөөр бүртгэж авснаар тайлант онд цэвэр ашигтай тайлагнагдаж ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэвэл ногдол ашгийг төлөх мөнгөн хөрөнгийн хомсдол үүсэх эрсдэлтэй байгаа	-	Зөвлөмж өгөх	Эрчим хүчний сайд, Ерөнхий нягтлан бодогч	Ц.Даваасүрэн П.Энхцэлмэг
3	Эрчим хүчний тариф шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор төсөвт байгууллагуудын цахилгаан дулааны зардлын төсвийг уялдуулан батлагдахгүй байгаагаас авлага, өглөгийн хэмжээ өссөн байна.	-	Зөвлөмж өгөх	Эрчим хүчний сайд, Ерөнхий нягтлан бодогч	Ц.Даваасүрэн П.Энхцэлмэг
4	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ЦДҮС ТӨХК-ийн хөрөнгө оруулалтын ажлын хөрөнгийн эх үүсвэрийг 2018 онд арилжааны банкны зээлээр санхүүжүүлэх шийдвэр гаргаж, 1,455.0 сая төгрөгийн зээлийн хүүгийн зардал төлсөн байна.	-	Зөвлөмж өгөх	Эрчим хүчний сайд, Ерөнхий нягтлан бодогч	Ц.Даваасүрэн П.Энхцэлмэг
5	Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 52,143.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 38,610.9 сая төгрөгийн алдааг залруулж, залруулагдаагүй 13,532.7 сая төгрөгийн алдаа зөрчил байна. Энэ нь харьяа байгууллагуудын санхүүгийн ажилтнуудын ур чадвар, чадавхыг дээшлүүлэх ажил хангалтгүй, дотоод хяналт үр нөлөөгүй байга	13,532.7	Зөвлөмж өгөх	Эрчим хүчний сайд, Ерөнхий нягтлан бодогч	Ц.Даваасүрэн П.Энхцэлмэг
Нийт дүн		13,532.7			

Хөрөнгө оруулалтын сан					
6	Тайлант онд 2 компанитай холбоотой нийт 21.4 сая төгрөгийн барьцааг суутган тооцоогүй байна.	21.4	Зөвлөмж өгөх	Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогч	Б.Ерөн-Өлзий П.Энхцэлмэг
7	Барьцаа хөрөнгийн дансанд 2010-2018 онд байршуулсан 2,390.1 сая төгрөгийн барьцааг гүйцэтгэгч байгууллагад буцаан өгөх болон улсын төсвийн орлого болгох эсэхийг шийдвэрлээгүй байна.	2,390.1	Зөвлөмж өгөх	Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогч	Б.Ерөн-Өлзий П.Энхцэлмэг
Нийт		2,411.5			

5.2 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Д/д	№	Харьяа байгууллага	Аудитад хамрагдсан хэлбэр					Нийт зөрчил		Залруулсан алдаа		Акт		Албан шаардлага		Зөвлөмж		Үүнээс:			
			Итгэл үзүүлсэн	Түүвэрт	Дүгнэлт			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		Хариуцлага тооцуулах санал	
					Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг											Дүгнэлт өгөхөөс татгалзсан	Тоо		Дүн
А		1	2	3	4	5	6	7	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ																					
I. ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН																					
1	1	Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан							2	1,020,951.6	2	1,020,951.6									
		ДҮН							2	1,020,951.6	2	1,020,951.6									
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БОЛОН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖ																					
IV. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БОЛОН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖ																					
1	1	ДЦС-2 ТӨХК			1				3	145.5	2	13.9					1	131.6			
2	2	ДЦС-3 ТӨХК			1				10	4,010.6	6	4,009.4	0	-	2	1.2	2	-			
3	3	ДЦС-4 ТӨХК			1				13	8,131.7	8	7,206.0	1	0.7	1	858.3	3	66.7			
4	4	Дарханы ДЦС-ТӨХК			1				7	128.2	2	18.7	1	1.7			4	107.8			
5	5	Эрдэнэтийн ДЦС-ТӨХК			1				3	6.7							3	6.7			
6	6	Улаанбаатар ЦТС- ТӨХК			1				15	2,697.8	0	-	1	433.3	2	376.6	12	1,887.9			
7	7	Багануур ЗӨБЦТС-ТӨХК			1				5	74.9							5	74.9			
8	8	Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК			1				8	4,245.0	5	1,125.0			1	1,576.1	2	1,543.9			
9	9	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК			1				7	2,779.1	3	2,343.2					4	435.9			
10	10	Дарханы дулааны сүлжээ ТӨХК			1				5	90.8					1	-	4	90.8			
11	11	Багануурын дулааны станц ТӨХК			1				5	2.8							5	2.8			
12	12	Налайхын дулааны станц ТӨХК			1				3	64.3							3	64.3			

13	13	Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК			1		8	445.9	6	372.8				2	73.1				
14	14	Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК			1		8	4,909.4	7	4,856.3				1	53.1				
15	15	Диспетчерийн үндэсний төв ХХК			1		8	528.1	1	112.8		1	-	6	415.3				
16	16	Дулаан шарын гол ТӨХК			1		5	51.8				2	-	3	51.8				
17	17	Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК			1		2	71.5						2	71.5				
18	18	Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК			1		6	124.6	2	74.8				4	49.8				
19	19	Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК			1		6	1,228.8	2	833.0				4	395.8				
20	20	Амгалан дулааны станц ХХК			1		14	1,213.7		1,091.9		4	110.1	10	11.7				
21	21	Эгийн голын усан цахилгаан станц ТӨХК			1		3	1,218.7	1	992.2		1	226.5	1	-				
22	22	Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК			1		7	1,088.1		-		5	959.2	2	128.9				
23	23	Улаангом дулааны 2-р станц ТӨХК			1			-		-	-	-	-	0	-				
24	24	Ховд дулааны станц ТӨХК			1		3	1,355.7	1	1,268.8				2	86.9				
25	25	Хөвсгөл дулааны станц ТӨХК			1		4	786.9	1	779.7				3	7.2				
26	26	Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ			1		4	34.5		-	-	-	-	4	34.5				
27	27	Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ			1		7	364.7	5	251.8		1	96.1	1	16.8				
28	28	Эрчим хүчний зохицуулах хороо			1		5	111.2	1	11.2		1	-	3	100.0				
29	29	Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ			1		4	15.0			1	1.4		3	13.6				
30	30	Таван толгойн түлш ХХК			1		9	11,167.0	1	10,644.2	1	8.2	1	6	514.6				
					ДҮН	28	2	187	47,093.0	54	36,005.7	5	445.3	23	4,204.1	105	6,437.9		
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ																			
V. ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ																			
1	1	Эрчим хүчний яам /аппарат/			1		11	2,410.1	4	2,377.1				7	33.0				
2	2	Эрчим хүчний яам /Хөрөнгө оруулалт/			1		2	2,411.5						2	2,411.5				
					ДҮН	1	1	13	4,821.6	4	2,377.1			9	2,444.5				
ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН НЭГЖ																			
VII. ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН НЭГЖ																			
1	1	Таван толгойн цахилгаан станц төсөл			1		3	229.0	2	228.1				1	0.9				
					ДҮН	1	3	229.0	2	228.1				1	0.9				
НИЙТ ДҮН			-	1	29	3	-	-	205	1,073,095.2	62	1,059,562.5	5	445.3	23	4,204.1	115	8,883.3	

5.3 ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН 2019 ОНЫ САХУУГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭГТЭЛД ХИЙСЭН АУДИТААР ТОГТООСОН ТӨЛБӨРИЙН АКТЫН НЭГТГЭЛ

Д/д	№	Харьяа байгууллага	Төлбөрийн акт тогтоосон зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая.төг/	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
					Албан тушаал	Овог нэр
А		1	2	3	4	5
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БОЛОН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖ						
IV. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БОЛОН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖ						
1	1	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК	Бэлтгэн нийлүүлэгчээс авах авлага дансанд 7 харилцагчийн 310.2 сая төгрөгийг шүүх хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэхээр хандсан боловч нотлох баримтын бүрдэлт хангалтгүй тул эцэслэн шийдвэрлэгдээгүй, 2 харилцагчийн 123.2 сая төгрөгийн авлага нь ажил үйлчилгээний чанарын шаардлага хангаагүй, нийт 433.3 сая төгрөгийн авлагыг он дамжин бүртгэж, үргүй зардал гаргасан байна.	433.3	Гүйцэтгэх захирал Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Ахлах нягтлан бодогч	Д.Баярсайхан О.Ариунболд Д.Төгсжаргал
2	2	Таван толгойн түлш ХХК	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд 8.2 сая төгрөгийн цалинг илүү тооцоолж олгосон байгаа нь Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн өмчит оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмын 3.7-д заасан заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.	8.2	Гүйцэтгэх захирал	М.Ганбаатар
3	3	Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК	Компанийн удирдах албан тушаалтны хэрэгцээнд ашиглагддаг суудлын автомашины шатахууны зарцуулалтын хэтрэлт хэмнэлтийг шалган үзэхэд Ландкрузер 200 маркын автомашины шатахууны зарцуулалт 366.4 литр буюу 0.7 сая төгрөгийг хэтрэлттэй байна.	0.7	Гүйцэтгэх захирал	Ү.Төмөрхуяг
4	4	Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК	Энх өлзий технологи ХХК-иас худалдан авсан слюдэгийн нэгжийн үнэ нь зах зээлийн үнээс өндөр нийт 1.7 сая төгрөг илүү байгаа нь НББ-ийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах", ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46.1.6-д "гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах" гэсэн заалтуудтай нийцээгүй ба үнэн, зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.	1.7	Гүйцэтгэх захирал Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга	М.Жаргалсайхан Ц.Ууганбаяр
5	5	Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ	Хүлээн авалтын зардал болон хувийн хэрэглээний зардалд төлсөн НӨАТ-ыг төсөвт төлөх НӨАТ-аас хасч тооцсон.	1.4	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Г.Эрдэнэжаргал
НИЙТ ТӨЛБӨРИЙН АКТЫН ДҮН				445.3		

5.4 ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН 2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТААР ХҮРГҮҮЛСЭН ТӨЛБӨРИЙН АЛБАН ШААРДЛАГЫН НЭГТГЭЛ

Д/д	№	Харьяа байгууллага	Албан шаардлагын товч утга	Мөнгөн дүн /сая.төг/	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
					Албан тушаал	Овог нэр
А		1	2	3	4	5
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БОЛОН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖ						
IV. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БОЛОН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖ						
1	1	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК	Баруун түгээх төвийн няраваас авах /бараа материалын дутагдал/ 19.3 сая төгрөг, өгөх 1.7 сая төгрөгийн өглөг нийт 17.6 сая төгрөгийн авлагыг барагдуулах, Гүйцэтгэх захирлын 2017 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 8/394 тоот тушаал гарсан боловч тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй, өглөг, авлагыг цэвэр бодит дүнгээр бүртгэж тайлагнаагүй байна.	17.6	Гүйцэтгэх захирал Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч	Д.Баярсайхан О.Ариунболд
	2		"УБЦТС" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал асан нь Налайх ХҮТ-ийн салбарыг оффистой болгоход зориулж 2012 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр иргэн Бадарай овогтой Баярсайханаас Налайх дүүргийн 01 дүгээр хороо, Уурхайчдын гудамж 20 тоот хаягт байрлалтай 357 м2 талбай бүхий объектыг, 182 м2 газрын хамт 200.0 сая төгрөгөөр худалдан авахаар 320/2012 тоот гэрээг байгуулж, 200.0 сая төгрөгийг шилжүүлсэн ба нэмж 159.0 сая төгрөгийн их засвар хийсэн байна. Уг объектыг зориулалтын дагуу ашиглаж, нягтлан бодох бүртгэлийн Үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн хэдий ч барилгын үл хөдлөх хөрөнгийн эрхийн гэрчилгээгүй эзэмшигч нь тодорхойгүй байна.	359.0	Гүйцэтгэх захирал Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Ахлах нягтлан бодогч	Д.Баярсайхан О.Ариунболд Д.Төгсжаргал
2	1	ДЦС-3 ТӨХК	Нийгмийн даатгалын тайланд ээлжийн амралтын олговрыг тухайн сард ногдох орлогоор нь харгалзах сард хуваарилдаггүй, мөн хөдөлмөрийн хөлс болон ээлжийн амралтын олговрыг 2 салгаж тайлагнаснаас даатгуулагчаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг илүү, дутуу суутгасан бөгөөд илүү, дутуу суутгуулсан ажилтнуудыг тэтгэвэрт гарах бүрт нийгмийн даатгалын залруулгын тайлан бүртгэдэг.	1.2	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч Ахлах нягтлан бодогч Цалингийн нягтлан бодогч	Ч.Чинбат Ц.Лхамсүрэн Ж.Ганцэцэг Ц.Хажидмаа
	2		Турбогенератор №7-ын их засварын ажлын үнэлгээний хорооны баталсан тендер шалгаруулалтын баталсан үзүүлэлтэд Эрчим хүчний яамнаас олгосон 3.2.1, 3.4.4, 3.5.4, 3.8.2 тоот тусгай зөвшөөрлүүдтэй байх шаардлагатай гэсэн боловч тендэрт шалгарсан компани 3.4.4 тоот тусгай зөвшөөрөлгүй байсан.	-	Гүйцэтгэх захирал Үнэлгээний хорооны дарга Засвар хяналтын албаны дарга	Ч.Чинбат Л.Нямхүү Ц.Батмагнай
3	1	Таван толгойн түлш ХХК	Тухайн байгууллага нь нийт 457 цэгээр дамжуулан шахмал түлшээ борлуулж байна. Борлуулалтын цэгийн борлуулагч нар нь 2.0 сая төгрөгийн барьцаа байршуулдаг бөгөөд барьцаа хөрөнгөнөөс илүү хэмжээний шахмал түлшийг зээлээр олгохгүй гэсэн борлуулагчийн гэрээтэй. Гэвч тайлант онд Улаанбаатар хотыг шахмал түлшээр таслахгүйн тулд борлуулагчдад барьцаанаас илүү хэмжээгээр шахмал түлшийг зээлээр олгожээ.	-	Ерөнхий нягтлан бодогч	П.Амарцэцэг
4	1	Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ	Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй	96.1	Захирал Нягтлан бодогч	А.Бямбадорж Д.Эрдэнэчимэг
5	1	Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК	Их засварын зардлын төсвөөс 226.8 сая төгрөг, урсгал засварын зардлаас 48.3 сая төгрөг, бараа материалын худалдан авалтын зардлаас 2.6 сая төгрөг нийт 277.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй үндсэн хөрөнгө худалдан авсан байна. Мөн Турбоагрегат №4-ийн их засварын ажилд 570.0 сая төгрөгийн материал төлөвлөж, 717.7 сая төгрөгийн материал, 432.9 сая төгрөгийн ажлын хөлсний	858.3	Төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга	Ж.Отгон Д.Төмөртоогоо

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

			гүйцэтгэл гарч төлөвлөсөн дүнгээс 580.6 сая төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан.			
6	1	Дарханы дулааны сүлжээ ТӨХК	Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй	-	Ерөнхий нягтлан бодогч	С.Лхагважаргал
7	1	Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК	Байгууллага тайлант онд алдагдалтай ажиллахад уул уурхайн компаниудад нийлүүлэх цахилгаан эрчим хүчний тариф, ДҮТ-ээс худалдан авах цахилгаан эрчим хүчний тарифийн зөрүү нөлөөлсөн.	1576.1	Эрчим хүчний зохицуулах хорооны дарга	А.Тлейхан
8	1	Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК	Тус компанийн өмчлөлийн Булган аймгийн Хялгант тосгонд байрлах 2 өрөө байрыг 2013 онд 1 давхарын 2 өрөө байраар сольж үйл ажиллагаагаа явуулж байсан боловч тус байрны өмчлөгч 1 давхарын байраа буцаан авахаар анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. Анхан шатны шүүхийн нэмэхлэхээр Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийг албадан гаргах шийдвэр гаргасан байна.	43.3	Хуулийн зөвлөх	С.Энхбат
	2		Бэлтгэн нийлүүлэгчид болон хувь хүнтэй холбоотой 7 харилцагчийн 64.2 сая төгрөг, цахилгаан эрчим хүчний борлуулалттай холбоотой 42 харилцагчийн 12.6 сая төгрөг, нийт 76.8 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	76.8	Ахлах нягтлан бодогч Борлуулалтын нягтлан бодогч	Г.Батгэрэл Б.Шийлэгмаа
	3		Аваарын нөөцөд бүртгэлтэй трансформаторуудаас түүвэрлэн биет тооллого хийхэд ТМ-35/15 1000 кв маркийн 43.6 сая төгрөгийн трансформатор биетээр оршин байхгүй байсан. Тус трансформаторыг байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллийн улмаас Говь-Алтай аймгийн Жаргалан, Баян-Уул зэрэг сумдууд сар гаруй хугацаанд цахилгаан хангамжгүй болсон тул Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-д Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэргүйгээр шилжүүлсэн байна.	43.6	Техникийн бодлогын хэлтсийн дарга Үндсэн хөрөнгө хариуцсан нягтлан бодогч	Б.Амарбаясгалан О.Анхтуяа
	4		Тендерийн баримт бичигт заасан шалгуурыг хангаагүй 795.5 сая төгрөгийн 11 оролцогчийг тендерт шалгаруулсан, тендерийн баримт бичгийн зарим заалтуудыг алдаатай боловсруулсан, тендерийн урилгад ирүүлэхээр заагдсан баримтыг тендерийн өгөгдлийн хүснэгтэд тусгаагүй, нээлтийн хурлын тэмдэглэлийг хуулийн дагуу хөтлөөгүй зэрэг зөрчлүүд илэрсэн.	795.5	ХҮХ-ийн дарга Тендерийн үнэлгээний хороо	Д.Гэрэлмаа Үнэлгээний хорооны дарга, гишүүд
	5		тайлант онд 250,007.2 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө батлагдсан байхад гүйцэтгэлээр 248,717.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 1,290.1 сая төгрөг буюу 0.5 хувиар орлогын төлөвлөгөөг тасалдуулсан.	-	Борлуулалтын хэлтсийн дарга	Ш.Дайрийжав
9	1	Эгийн голын усан цахилгаан станц ТӨХК	Цалингийн нэмэгдлийг 100 хувиар тооцон хавтгайруулан 226.5 сая төгрөгийг олгосон байна.	226.5	Захирал Нягтлан бодогч	Т.Болдбаатар Ж.Отгонбаяр
10	1	Диспетчерийн үндэсний төв ХХК	Компанийн шуурхай ажиллагааны зориулалтаар 2018 онд худалдан авсан туулах чадвар сайтай Ланд-TLC200 маркын автомашиныг тус компанийн гүйцэтгэх захирал хот дотор зориулалт бусаар ашиглаж, шатахууны үргүй зардал гаргаж байгааг таслан зогсоож, цаашид албан ажлын болон тусгай зориулалтын автомашины ашиглалтад тавих хяналтыг сайжруулж ажиллахыг өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж болгосоныг хэрэгжүүлээгүй, зөрчлийг дахин давтан гаргаж байна.	-	Гүйцэтгэх захирал Санхүү, эдийн засгийн хэтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч	Г.Балжинням А.Цагаансар
11	1	Эрчим хүчний зохицуулах хороо	Тайлант онд орлогын төлөвлөгөө 507.1 сая төгрөгөөр давсан, 581.2 сая төгрөгийн зардлын хэмнэлт үүссэн зэргээс 1206.6 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэл байгаа нь зохицуулалтын үйлчилгээний хөлсийг өндрөөр тогтоосон, орлого, үйл ажиллагааны зардлыг үндэслэлгүй тогтоодогтой холбоотой байна.	-	Дарга Ахлах нягтлан бодогч	А.Тлейхан М.Мандах

12	1	Дулаан шарын гол ТӨХК	Зорилтот түвшний орлогын төлөвлөгөө тасарсан, авлага, өр, төлбөр нэмэгдсэн.	-	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Б.Энхцэцэг Ж.Даш
	2		Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөл аваагүй, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр арилжааны банкнаас богино хугацаат зээл авч өглөг үүсгэсэн.	-	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Б.Энхцэцэг Ж.Даш
14	1	Амгалан дулааны станц ХХК	Монгол Хьюндай автомотив ХХК-ийг суудлын автомашин нийлүүлэх тендерт гүйцэтгэгчээр сонгосон байна. Тендер захиалагч, тендер гүйцэтгэгч нар худалдах, худалдан авах гэрээг байгуулахаас өмнө тендерийн баталгааны хугацаа дууссан байна.	-	ААХА-ны дарга	Г.Амарбаясгалан
	2		17.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тавилга, эд хогшил нийлүүлэх тендерийн гүйцэтгэгч Монрубин ХХК-тай 18.9 сая төгрөгөөр шууд гэрээ байгуулсан байна. Гэрээний нэмэлт дүн нь тендерийн төсөвт өртгийн 5%-иар хэтэрсэн байна.	17.2	ААХА-ны дарга	Г.Амарбаясгалан
	3		45.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТУСП сэлбэг хэрэгсэл нийлүүлэх тендерийн гүйцэтгэгч Хүчит Хөтлүүр ХХК бараа материал нийлүүлэх гэрээгээ цуцлах хүсэлт гаргасан тул шууд гэрээг Энитайм И Гурав ХХК-тай байгуулсан байна. Мөн 18.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилгын материал, түүний дагалдах хэрэгсэл нийлүүлэх тендер шалгаруулалт амжилтгүй болсон тул шууд гэрээ байгуулах аргыг сонгосон тул Алво ХХК-ийг тендер гүйцэтгэгчээр сонгохдоо бусад компанийн үнийн саналтай харьцуулалт хийгээгүй сонгосон байна.	64.4	ААХА-ны дарга	Г.Амарбаясгалан
	4		15.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй багаж нийлүүлэх, 12.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй сэлбэг хэрэгслийн худалдан авалтад тендерийн харьцуулалтын арга ашиглалгүй шууд гэрээ байгуулах аргыг ашиглаж худалдан авалтуудыг хийсэн байна.	28.5	ААХА-ны дарга	Г.Амарбаясгалан
НИЙТ ДҮН				4,204.1		